

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/08/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn

Мөрөн сум
2023 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 цахим
хаяг: tegsndelgerb@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn
Аудитор: Л.Мөнх-Оргил
Утас: 99039344 цахим хаяг: orgil.ikhuul@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|---|----|
| 1. АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ..... | 3 |
| Асуудлыг онцолсон хэсэг..... | 3 |
| Аудитын гол асуудал..... | 3 |
| 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан..... | 5 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан..... | 5 |
| 2.2 Аудит хийсэн орлогын тайлан..... | 6 |
| 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан..... | 7 |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан..... | 7 |
| 2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл..... | 9 |
| 3. Санхүүгийн тайлангийн тодруулга..... | 10 |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа..... | 10 |
| 3.2 Байгууллагын гадаад дотоод орчин..... | 10 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал..... | 11 |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд..... | 11 |
| 3.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл..... | 12 |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН..... | 12 |
| 4.1 Ерөнхий зүйл..... | 12 |
| 4.2 Материаллаг байдал..... | 12 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт..... | 12 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..... | 13 |
| 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт..... | 13 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт..... | 13 |
| 4.5.1 Завсрын аудитын талаар..... | 13 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал:..... | 14 |
| 5. Аудитын илрүүлэлт..... | 14 |
| 5.3 Албан шаардлага..... | 14 |
| 5.4 Зөвлөмж..... | 14 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|--|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| СТОУС | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТУЗ | Төлөөлөн удирдах зөвлөл |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.03.15 № 01/273
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН
ХЯНАЛТЫН ТӨВ ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Д. БАТЧУЛУУН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГ нь тайлант онд бизнес төлөвлөгөөнд тусгагдаж батлагдсан орлогыг 66.1 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн нь алдагдалтай ажиллах шалтгаан болсон байна. Мөн төлөвлөгөөнд батлагдсанаар 2.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар нийгмийн даатгалын шимтгэлийн зардалтай холбоотой асуудалд төлбөрийн акт, санхүүгийн тайланг аудитын байгууллагад хуулийн хугацаанд хүргээгүй, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчлүүдэд албан шаардлага, санхүүгийн тайланг хуульд заасан иж бүрдлээр бүрэн тайлагнах талаар зөвлөмж өгч ажиллаа.

Бусад асуудлын хэсэг

Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГ нь 2022 оны зорилтот түвшний хүлээгдэж буй гүйцэтгэлийг 94.6 хувийн биелэлттэй гэж тайлагнажээ. Бусад мэдээлэл болох бизнес төлөвлөгөөний тайлан, байгууллагын бусад үйл ажиллагаа, нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно. Компанийн удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 23,107,660.64 | 17,080,776.93 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 11,425,427.49 | 1,445,834.88 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 11,425,427.49 | 1,445,834.88 |
| 3121 | Төгрөг | 11,425,427.49 | 1,445,834.88 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 11,425,427.49 | 1,445,834.88 |
| 33 | АВЛАГА | 19,001.15 | 60,900.05 |
| 335 | Бусад авлага | 19,001.15 | 60,900.05 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 19,001.15 | 60,900.05 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 11,663,232.00 | 15,574,042.00 |
| 351 | Түүхий эд материал | 00.00 | 432,000.00 |
| 35130 | Эм боох материал | 00.00 | 432,000.00 |
| 354 | Хангамжийн материал | 11,663,232.00 | 15,142,042.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 421,000.00 | 1,414,350.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 238,500.00 | 2,906,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 3,053,840.00 | 550,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 7,949,892.00 | 10,271,692.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 129,702,675.00 | 111,319,324.90 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 129,702,675.00 | 111,319,324.90 |
| 392 | Биет хөрөнгө | 129,702,675.00 | 111,319,324.90 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 111,400,000.00 | 111,400,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -1,725,000.00 | -12,864,999.96 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 25,377,000.00 | 25,377,000.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -13,809,125.00 | -22,599,500.00 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 9,847,000.00 | 12,584,000.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -1,387,200.00 | -2,577,175.14 |
| 39301 | Програм хангамж | 220,000.00 | 220,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -220,000.00 | -220,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 152,810,335.64 | 128,400,101.83 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 3,113,071.68 | 3,200,896.52 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 3,113,071.68 | 3,200,896.52 |
| 413 | Өглөг | 3,113,071.68 | 3,200,896.52 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 2,092,669.09 | 1,249,336.52 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 00.00 | 1,209,560.00 |
| 4136 | Бусад өглөг | 1,020,402.59 | 742,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 1,020,402.59 | 742,000.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 149,697,263.96 | 125,199,205.31 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 149,697,263.96 | 125,199,205.31 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 11,500,000.00 | 11,500,000.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 11,500,000.00 | 11,500,000.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 138,197,263.96 | 113,699,205.31 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 138,197,263.96 | 138,197,263.96 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -24,498,058.65 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 152,810,335.64 | 128,400,101.83 |

2.2 Аудит хийсэн орлогын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 271,935,500.00 | 209,480,049.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 271,935,500.00 | 209,480,049.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 271,935,500.00 | 209,480,049.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 271,935,500.00 | 209,480,049.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 271,935,500.00 | 159,511,700.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 49,968,349.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 170,915,642.11 | 233,978,107.65 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 170,915,642.11 | 233,978,107.65 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 170,915,642.11 | 232,478,107.65 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 98,990,988.40 | 136,389,856.35 |
| 210101 | Үндсэн цалин | 98,990,988.40 | 136,389,856.35 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 14,321,702.60 | 17,053,384.18 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,411,894.58 | 12,293,721.52 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,216,363.44 | 1,363,898.03 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 970,157.28 | 1,091,118.02 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 156,661.93 | 175,251.08 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,566,625.37 | 2,129,395.53 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 8,165,268.50 | 9,138,167.60 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 00.00 | 399,938.00 |
| 210302 | Түлш, халаалт | 00.00 | 1,377,129.60 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 198,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 8,165,268.50 | 7,163,100.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 16,105,390.00 | 22,730,857.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,802,850.00 | 2,548,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,096,160.00 | 15,078,840.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,319,770.00 | 2,942,585.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,886,610.00 | 2,062,082.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 00.00 | 98,450.00 |
| 2105 | Нормативт зардал | 00.00 | 180,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 00.00 | 180,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,674,100.00 | 7,553,032.40 |
| 210604 | Урсгал засвар | 5,674,100.00 | 7,553,032.40 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 9,687,400.00 | 11,699,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,687,400.00 | 11,699,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,095,092.61 | 786,774.02 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,500,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,060,000.00 | 599,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 133,950.00 | 111,474.02 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 344,200.00 | 33,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 36,540.00 | 42,800.00 |
| 210814 | Орлогын татварын зардал /ТӨҮГ/ | 1,020,402.61 | 00.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,875,700.00 | 26,947,036.10 |

"Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв" ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 25,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 665,000.00 | 5,800,786.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 12,210,700.00 | 21,120,350.10 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 00.00 | 1,500,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 00.00 | 1,500,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 00.00 | 1,500,000.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 101,019,857.89 | -24,498,058.65 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 101,019,857.89 | -24,498,058.65 |

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|---------------------------------------|---------------------------------|-------------------|---|
| C01 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 101,019,857.89 | 101,019,857.89 |
| C08 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 11,500,000.00 | 138,197,263.96 | 149,697,263.96 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 11,500,000.00 | 138,197,263.96 | 149,697,263.96 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -24,498,058.65 | -24,498,058.65 |
| D09 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 11,500,000.00 | 113,699,205.31 | 125,199,205.31 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 271,935,500.00 | 209,480,049.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 271,935,500.00 | 209,480,049.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 271,935,500.00 | 209,480,049.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 271,935,500.00 | 209,480,049.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 271,935,500.00 | 159,511,700.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 49,968,349.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 152,954,836.20 | 216,722,641.61 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 152,954,836.20 | 216,722,641.61 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 152,954,836.20 | 215,222,641.61 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 77,721,327.00 | 137,481,792.88 |
| 210101 | Үндсэн цалин | 77,721,327.00 | 137,481,792.88 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 27,320,000.70 | 16,846,679.12 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,320,000.70 | 16,324,281.12 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 522,398.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 8,165,268.50 | 9,138,167.60 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 00.00 | 399,938.00 |

"Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв" ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 210302 | Түлш, халаалт | 00.00 | 1,377,129.60 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 198,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 8,165,268.50 | 7,163,100.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 20,041,450.00 | 20,847,293.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,802,850.00 | 2,869,450.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,091,160.00 | 12,575,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,319,770.00 | 2,753,325.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,827,670.00 | 2,649,518.00 |
| 2105 | Нормативт зардал | 00.00 | 612,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 00.00 | 612,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,674,100.00 | 10,820,632.40 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 89,800.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 880,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,674,100.00 | 9,850,832.40 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 9,687,400.00 | 11,699,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,687,400.00 | 11,699,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,230,490.00 | 2,357,176.61 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,193,950.00 | 599,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 00.00 | 111,474.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 00.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 550,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 36,540.00 | 42,800.00 |
| 210816 | Татварын байгууллагад төлсөн ЛӨҮГ/ | 00.00 | 1,020,402.61 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,114,800.00 | 5,419,900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,449,800.00 | 25,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 665,000.00 | 5,394,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 00.00 | 1,500,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 00.00 | 1,500,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 00.00 | 1,500,000.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 118,980,663.80 | -7,242,592.61 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 106,566,000.00 | 2,737,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 106,566,000.00 | 2,737,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 106,566,000.00 | 2,737,000.00 |
| 225101 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн ЛӨҮГ/ | 106,566,000.00 | 00.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 2,737,000.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | 106,566,000.00 | -2,737,000.00 |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 12,414,663.80 | (9,979,592.61) |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 7,047,176.10 | 11,425,427.49 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 11,425,427.50 | 1,445,834.88 |

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл /төгрөгөөр/

| № | Үзүүлэлт | 2021 оны гүйцэтгэл | 2022 оны | | | Хувь (%) |
|--------------------|--|----------------------|----------------------|----------------------|---------------------|-------------|
| | | | Төлөвлөлт | Гүйцэтгэл | Зөрүү | |
| ОРЛОГО | | | | | | |
| 1 | Харилцах дансны эхний үлдэгдэл | 7,047,176.0 | 11,425,427.6 | 11,425,427.6 | - | 100.0 |
| 2 | 2022 оны улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн хяналтын орлого | 271,935,500.0 | 178,786,790.0 | 159,511,700.0 | 19,275,090.0 | 89.2 |
| 3 | Сум орон нутагт хийгдэх захиалагчийн хяналтын орлого | - | 68,875,000.0 | 31,968,349.0 | 36,906,651.0 | 46.4 |
| 4 | Аймагт баригдаж байгаа барилга байгууламжид гэрээгээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх орлого | - | 28,122,000.0 | 18,000,000.0 | 10,122,000.0 | 64.0 |
| ОРЛОГО ДҮН: | | 278,982,676.0 | 287,209,217.6 | 220,905,476.6 | 66,303,741.0 | 74.9 |
| ЗАРЛАГА | | | | | | |
| 1 | Үндсэн ба нэмэгдэл цалин | 98,990,988.3 | 137,330,000.0 | 133,681,792.9 | 3,648,207.1 | 97.3 |
| 2 | Урамшуулал | 1,742,670.0 | 11,970,000.0 | 5,300,000.0 | 6,670,000.0 | 44.3 |
| 3 | Нийгмийн даатгал /Ажил олгогч/ | 14,321,702.5 | 18,662,500.0 | 16,846,679.1 | 1,815,820.9 | 90.3 |
| 4 | Албан томилолтын зардал | 9,687,400.0 | 12,856,500.0 | 11,699,000.0 | 1,157,500.0 | 91.0 |
| 5 | Бичиг хэргийн зардал | 1,802,850.0 | 3,622,000.0 | 2,869,450.0 | 752,550.0 | 79.2 |
| 6 | Хангамжийн материалын зардал | - | 2,904,000.0 | 3,261,518.0 | (357,518.0) | |
| 7 | Шуудан, харилцаа холбооны зардал | 3,319,770.0 | 3,001,000.0 | 2,753,325.0 | 247,675.0 | 91.7 |
| 8 | Урсгал засвар /автомашин | 5,674,100.0 | 3,730,000.0 | 5,225,900.0 | (1,495,900.0) | |
| 9 | Тээвэр, шатахууны зардал | 7,096,160.0 | 12,575,900.0 | 12,575,000.0 | 900.0 | 100.0 |
| 10 | Хөдөлмөр хамгааллын зардал | 1,760,000.0 | 1,920,000.0 | 880,000.0 | 1,040,000.0 | 45.8 |
| 11 | Сургалтын зардал | 665,000.0 | 5,835,000.0 | 5,394,000.0 | 441,000.0 | 92.4 |
| 12 | Автомашин татвар, үзлэг оношилгоо | 128,200.0 | 528,000.0 | 144,474.0 | 383,526.0 | 27.4 |
| 13 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал /банк/ | 1,844,200.0 | 1,220,000.0 | 68,700.0 | 1,151,300.0 | 5.6 |
| 14 | Даатгалын зардал | 2,193,950.0 | 1,400,000.0 | 599,500.0 | 800,500.0 | 42.8 |
| 15 | Багаж хэрэгсэл | 956,000.0 | 15,940,000.0 | 89,800.0 | 15,850,200.0 | 0.6 |
| 16 | Программ хангамж | | 3,150,000.0 | 550,000.0 | 2,600,000.0 | 17.5 |
| 17 | Оффис ерөөний засвар | - | 4,214,500.0 | 4,624,932.4 | (410,432.4) | |
| 18 | Автомашин худалдан авах | 99,900,000.0 | | | - | - |

| | | | | | | |
|----|---|----------------------|----------------------|----------------------|---------------------|-------------|
| 19 | Компьютер, тоног төхөөрөмж | 6,666,000.0 | 2,050,000.0 | | 2,050,000.0 | - |
| 20 | Тавилга эд хогшил | - | 1,900,000.0 | 2,737,000.0 | (837,000.0) | |
| 21 | Түрээсийн зардал /байр ашиглалтын зардал/ | 8,165,268.5 | 11,100,000.0 | 9,138,167.6 | 1,961,832.4 | 82.3 |
| 22 | Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал | 12,210,700.0 | 25,073,200.0 | 21,120,350.1 | 3,952,849.9 | |
| | ЗАРДЛЫН ДҮН: | 277,124,959.3 | 280,982,600.0 | 239,559,589.1 | 41,423,010.9 | 85.3 |
| 1 | АШИГ АЛДАГДАЛ | 1,857,716.7 | 6,226,617.6 | (18,654,112.5) | 24,880,730.1 | |
| 2 | Татварын өглөг | 185,771.7 | 4,397,008.0 | 1,020,402.7 | 3,376,605.3 | 23.2 |
| 3 | НИЙТ АШИГ АЛДАГДАЛ | 1,671,945.0 | 1,829,609.6 | (19,674,515.2) | 21,504,124.8 | |

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГ-ын зорилго нь Хөвсгөл аймгийн хэмжээнд хэрэгжиж байгаа дэд бүтцийн барилга угсралтын ажилд захиалагч-гүйцэтгэгч-ашиглагчийн мэргэшсэн зөвлөх нь байж хариуцлагатай чадварлаг гүйцэтгэгчийг төлөвшүүлэхэд оршино, Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг "Улсын төсвийн болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй барилга байгууламж, дулааны шугам сүлжээ эх үүсвүүр, зам гүүр холбоо дохиолол, усан хангамж ариутгах татуурга, цахилгаан хангамж зэрэг захиалагчийн хяналт хийх" гэж тодорхойлжээ. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг орон нутаг эзэмшиж байна.

3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГ-ыг Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн "Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулах тухай" 75 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйл "Орон нутгийн өмчийн талаарх иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг бүрэн эрх"-ийн 77.2¹, 77.4² гэсэн заалттай нийцэж байна.

Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГ нь ТУЗ-гүй бөгөөд аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлтэй байна. Тус зөвлөл нь байгууллагын бизнес төлөвлөгөөг баталж, үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд нөлөөлөхүйц хэмжээний өөрчлөлт гараагүй байна.

Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн "Төрийн хэмнэлтийн тухай" хууль хэрэгжиж эхэлсэн.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д заасны дагуу дотоод хяналт шалгалт хийх нэгж, ажилтныг 2022 оны 05 сарын 04-ний өдрийн А/11 дүгээр захирлын тушаалаар томилсон байна. Тус ажлын хэсэг нь

¹ "Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй"

² "орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих"

жилийн ажлын төлөвлөгөө боловсруулан хяналтыг хийж хэрэгжүүлсэн байна. Биелэлтийг хагас бүтэн жилээр гарган, байгууллагын хурлаар танилцуулан ажилласан байна.

Тус байгууллага нь захирлын 2021 оны 10 сарын 12-ны өдрийн тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

"Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв" ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 24.5 сая төгрөгөөр буюу 15.9 хувиар буурсан байна.

Байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|----------------|-----------------|---------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 11.4 | 1.4 | -10.0 |
| Дансны авлага | 0.0 | 0.1 | 0.0 |
| Бараа материал | 11.7 | 15.6 | 3.9 |
| Үндсэн хөрөнгө | 129.7 | 111.3 | (18.4) |
| Нийт хөрөнгө | 152.8 | 128.8 | (24.4) |
| Дансны өглөг | 3.1 | 3.2 | 0.1 |
| Эздийн өмч | 11.5 | 11.5 | - |
| -төрийн | 11.5 | 11.5 | - |
| Хуримтлагдсан үр дүн | 138.2 | 114.1 | (24.5) |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 152.8 | 128.8 | (24.5) |

Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГ -ын харилцах данс нь Төрийн банканд байршдаг бөгөөд харилцах дансанд 1.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлагын үлдэгдэлд НДШ-ийн 0.06 сая төгрөгийн авлага байна. Бараа материалын дансны үлдэгдэл 15.6 сая төгрөг болж 3.9 сая төгрөгөөр өссөн нь шатахууны зардлын зарцуулаагүй үлдэгдэл буюу талон, зайлшгүй шаардлагатай ажлын хэрэгслийн өсөлтөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансанд шинээр 2.7 сая төгрөгийн албан хэрэгцээнд ширээ сандал худалдан авсан байна. Тайлант онд акталж устгасан үндсэн хөрөнгө байхгүй байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 3.2 сая төгрөгийн өр төлбөртэй байгаа нь суутган 1.2 сая төгрөг, бусад тооцооны өглөг 2.0 сая төгрөг байна.

Хуримтлагдсан үр дүн 24.5 сая төгрөгөөр буурсан байна.

3.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Компанийн гүйцэтгэх захирагч нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн Засаг даргын 2022 оны А/56 дугаар захирамжаар Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГ-ын 2022 онд ажиллах бизнес төлөвлөгөө, орон тоог баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 287.2 сая төгрөгөөр, нийт зардлыг 285.3 сая төгрөгөөр, 1.8 сая төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГ-ын байгууллагын дотоод хяналтын нэгжийг томилон, төлөвлөгөө боловсруулан дотоод хяналтын сайжруулах, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, алдаа зөрчлийг таслан зогсоох, 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд аудитын байгууллагад ирүүлээгүй тул холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох зэрэг нийт 3 албан шаардлага, 6 иргэний нийгмийн даатгалын шимтгэл төлсөн 0.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, үндсэн хөрөнгө, бараа материалын данстай холбоотой 0.7 сая төгрөгийн залруулга хийсэн болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын аудитор Л.Мөнх-Оргил гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

"Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв" ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 03-ний өдрийн 01/30 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБӨУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 170.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 3.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн

байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй асуудал илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГ-ын тайлант онд шилэн дансны нэгдсэн цахим системд байршуулсан мэдээллийг хянаж үзэхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Цалингийн зардлаас бусад 5 саяас дээш үнийн дүн бүхий орлогын мэдээлэл 3 удаагийн 45,000,000 /дөчин таван сая / төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна.
- Тайлант оны 1-5 дугаар сард Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.
- Бүтэн жилээр оруулах мэдээллээс байгууллагын худалдан авах ажиллагааны тайланг мэдээлээгүй байна.
- Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Дээрх зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дах заалттай нийцэхгүй байгаа ба "нийцсэн бөгөөд зохистой" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаандаа мэдээлээгүй зөрчилд хуульд заасан мэдээллийг тогтоосон хугацаанд иж бүрэн, үнэн зөв мэдээлж байх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд:

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж үзлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

"Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв" ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хөвсгөл аймгийн "Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв" ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1.2 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж, 104.8 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өгөгдсөн ба хэрэгжилт 60%-тай байна.

Хүснэгт 4 албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-----------------|------------------------|--------------|----------|--------------|-----------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 3 | 1.2 | 2 | 1.2 | 66.7 |
| Албан шаардлага | 2 | 104.8 | 1 | 104.8 | 50 |
| Нийт дүн | 5 | 106.0 | 3 | 106.0 | 60 |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал:

Дараагийн аудитаар давтан шалгах онцгой асуудал байхгүй байна.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 46.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0.7 сая төгрөгийн алдааг залруулж, 45.0 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 0.6 сая төгрөгийн алдаа зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, санхүүгийн тайлангийн иж бүрдлийн талаар 1 зөвлөмж өгсөн болно.

Аудитаар илэрсэн 45.0 сая төгрөгийн зөрчил нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой байгаа тул санхүүгийн тайланд материаллаг бусаар нөлөөлж байна гэж үзлээ.

Залруулагдаагүй 0.6 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон 2.7 сая төгрөгийн түвшнээс 2.1 сая төгрөгөөр бага байгаа тул "Өөрчлөлтгүй" санал дүгнэлт өглөө.

5.1 Залруулсан алдаа

Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 0.4 сая төгрөгийн бараа материалын шинж чанартай хөрөнгийг үндсэн хөрөнгөнд бүртгэсэн, тайлант оны элэгдлийн зардал дутуу тооцсон 0.3 сая төгрөгийн залруулгыг аудитын хугацаанд хийсэн болно.

5.2 Төлбөрийн акт

Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар тус байгууллагын дарга нь 6 иргэнтэй 2022 оны 09 сарын 01-ний өдөр хамтран ажиллах гэрээ байгуулж, ажиллаагүй байхад нийгмийн даатгалын шимтгэлд тухайн байгууллагын төсвөөс 0.6 сая төгрөгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчин зарцуулсан байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтуудтай нийцэхгүй байгаа ба "толилуулга ба тодруулга" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.3 Албан шаардлага

"Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв" ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилд үндэслэн дараах 2 албан шаардлагыг өгөхөөр шийдвэрлэлээ. Үүнд:

1. Тайлант оны санхүүгийн тайланг аудит хийлгэхээр 2023 оны 03 сарын 01-ний өдөр Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8³ дах заалттай нийцэхгүй байгаа ба "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Тайлант онд шилэн дансны нэгдсэн цахим системд байршуулсан мэдээллийг хянаж үзэхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Цалингийн зардлаас бусад 5 саяас дээш үнийн дүн бүхий орлогын мэдээлэл 3 удаагийн 45,000,000 /дөчин таван сая / төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна.
- Тайлант оны 1-5 дугаар сард Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.
- Бүтэн жилээр оруулах мэдээллээс байгууллагын худалдан авах ажиллагааны тайланг мэдээлээгүй байна.
- Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

³ "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15- ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх"

Дээрх зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дах заалттай нийцэхгүй байгаа ба "нийцсэн бөгөөд зохистой" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн иж бүрдлийн талаар

Илрүүлэлт:

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ Сангийн сайдын 361 дүгээр тушаал, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1 дэх заалтад заасан бүрэлдэхүүнийг хангаж ирүүлээгүй байна. Энэ нь эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Тухайлбал: Санхүүгийн тайлангийн тодруулга, толилуулгыг бэлтгээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, сангийн сайдын 361 дүгээр тушаалын холбогдох заалтын дагуу санхүүгийн тайланг иж бүрэн бэлтгэж, аудитын байгууллагад ирүүлж байх.

Дээрх акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Аудитаар илэрсэн алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|--|------------|------------|-----------------------------------|------------|--------------------------|------------|------------|------------|--------------|-----|---------|-----|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | | Тоо | Дүн |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| Бараа материалыг үндсэн хөрөнгөнд бүртгэсэн. | 1 | 0.4 | 1 | 0.4 | | | 1 | 0.4 | | | | |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл дутуу бодсон. | 1 | 0.3 | | | 1 | 0.3 | 1 | 0.3 | | | | |
| Дүн | 2 | 0.7 | 1 | 0.4 | 1 | 0.3 | 2 | 0.7 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|--|-------------|------------|---------------|------------|-----------------|----------|----------|----------|--------------------------------------|-----|---|-----|
| | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Ажиллаагүй 6 иргэнд цалин олгоогүй ба Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн. | 1 | 0.6 | 1 | 0.6 | | | | | | | | |
| Санхүүгийн тайлан хугацаа хоцроож ирүүлсэн. | 1 | - | | | 1 | - | | | | | | |
| Санхүүгийн тайлан бүрэн ирүүлээгүй. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Дүн | 3 | 0.6 | 1 | 0.6 | 1 | - | 1 | - | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|-------------|-------------|---------------|-----|-----------------|-------------|---------|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Мэдээлэл Оруулаагүй болон хугацаа хоцроож мэдээлсэн. | 1 | 45.0 | | | 1 | 45.0 | | |
| Нийт дүн | 1 | 45.0 | | | 1 | 45.0 | | |



ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
 АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
 АУДИТЫН МЕНЕЖЕР
 АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:
 Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:
 Б.ДАВААНЯМ ОГНОО:

ГҮЙЦЭТГЭСЭН:

АУДИТОР

Л.МӨНХ-ОРГИЛ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 сарын 15 өдөр

№ 52/А2291129ХӨА-2023
08/НА-СТА-ОНА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Цалингийн зардлаас бусад 5 саяас дээш үнийн дүн бүхий орлогын 45,000,000 /дөчин таван сая / төгрөгийн 3 мэдээллийг мэдээлээгүй байна.
- Тайлант оны 1-5 дугаар сард Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.
- Бүтэн жилээр оруулах мэдээллээс байгууллагын худалдан авах ажиллагааны тайланг мэдээлээгүй.
- Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах зөвлөмж хүргүүлсэн хэдий ч хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Дээрх зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дах заалттай нийцэхгүй байгаа ба “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тоот тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр өгөөжтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь үнэн зөв мэдээлж ажиллах;
2. Албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 10-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ нотлох баримтын хамт ирүүлэхийг Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГ-ын захирал Д. Батчулуун, нягтлан бодогч Н.Хонгорзул нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

АУДИТОР:

Л.МӨНХ-ОРГИЛ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот, Утас: 7038-4043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 сарын 15 өдөр

№ 53/А227/129ХӨА-2023
08/НА-СТА-ОНА

Мөрөн сум

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тус байгууллагын нягтлан бодогч нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацааг хоцроож 2023 оны 03 дугаар сарын 3-ны өдөр Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8. "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15- ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх" гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.2-д "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ** нь:

- Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГ-ын нягтлан бодогч Н.Хонгорзулд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ нотлох баримтын хамт ирүүлэхийг Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГ-ын захирал Д.Батчулуунд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

АУДИТОР:

Л.МӨНХ-ОРГИЛ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас:70384043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2023 оны 03 сарын 15 өдөр

№ 44/1227/129ХӨА-2023
08/НА-СТА-ОНА

Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Байгууллагын захирал нь 2022 оны 09 сарын 01-ний өдөр 6 иргэнтэй хамтран ажиллах гэрээ байгуулан, ямар нэгэн ажил хийсэн нь анхан шатны баримтаар нотлогдоогүй байхад нийгмийн даатгалын шимтгэлд байгууллагын төсвөөс 586,320 (таван зуун наян зургаан мянга гурван зуун хорин) төгрөгийг төлсөн байна.

Дээрх зөрчил нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” заалтуудтай нийцэхгүй байгаа ба “толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Байгууллагын төсвөөс ажил гүйцэтгээгүй байхад 6 хүний нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн нийт 586,320 (таван зуун наян зургаан мянга гурван зуун хорин) төгрөгийг Хөвсгөл аймгийн төрийн санд байрших 100170000955 тоот /Хө. Бусад нэр заагдаагүй орлого/ дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ нотлох баримтын хамт ирүүлэхийг Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГ-ын дарга Д.Батчулуун, нягтлан бодогч Н.Хонгорзул нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

АУДИТОР:

Л.МӨНХ-ОРГИЛ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас:70384043